

I. Товч дүгнэлт

Хүснэгт 1: Төслийн нэгдсэн мэдээлэл

Төслийн нэр:	“Байгаль нуурын сав газрын хил дамнасан экосистемийн байгалийн нөөцийн нэгдсэн менежмент”			
ДДБОС төслийн дугаар:	4029		<u>Гарын үсэг зурахад (ам.доллар)</u>	<u>дуусахад (ам.доллар)</u>
НҮБХХ төслийн дугаар:	4347 АТЛАС-ын дугаар: 00076781	ДДБОС санхүүжилт:	Ам. доллар3,898,000	Ам. доллар3,898,000
Улс :	ОХУ, Монгол Улс	IA/EA own:		
Бүс нутаг:	Европ & CIS	Засгийн Газар:		
Гол салбар:	Олон Улсын Ус, Биологийн олон янз байдал	Бусад:		
FA Зорилтууд, (OP/SP):	Стратеги бодлого ба төлөвлөлтийн үндэс, Усны нөөцийн нэгдсэн менежментийн бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх, Усны чанар, биологийн олон янз байдлыг хамгаалах туршлага нэвтрүүлэх.	Нийт хамтын санхүүжилт:	Тусламж бэлэн мөнгөөр: Байгаль нуурыг хамгаалах сан: ам.\$3,387,097 Кока-Кола: ам.\$300,000 НҮББШУСБ: ам.\$ 315,000 Тусламж бэлэн бус: Үндэсний Засгийн Газар Ам.\$15,161,290 Орон нутгийн захиргаа ам.\$30,124,782	Тусламж бэлэн мөнгөөр: Байгаль нуурыг хамгаалах сан: ам.\$3,387,097 Кока-Кола: ам.\$300,000 НҮББШУСБ: ам.\$ 315,000 Тусламж бэлэн бус: Үндэсний Засгийн Газар Ам.\$15,161,290 Орон нутгийн захиргаа ам.\$30,124,782
Гүйцэтгэгч байгууллага:	НҮБ-ын ТҮА (UNOPS)	Төслийн нийт зардал:	Ам.\$53,186,169	Ам.\$53,186,169
Бусад хамтрагчид:	НҮББШУСБ, Байгалийн нөөц ба байгаль орчны холбооны яам (ОХУ); БОНХЯам (Монгол Улс)	Төслийн баримт бичигт гарын үсэг зурсан (төсөл эхэлсэн он, сар, өдөр):		2011 оны 6-р сарын 20 өдөр
		Дуусах хугацаа:	2015оны 12-р сарын 31 өдөр	

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА БА ТОЙМ

1. Байгаль нуурын төслийн төлөвлөсөн 53.19 сая ам. долларын зардлын 49.29 сая ам. долларыг хамтран санхүүжүүлэхээр анхлан төлөвлөсөн байсны 3.90 сая ам. долларыг ДДБОС-гийн буцалтгүй тусламжийн хэлбэрээр (төсөл боловсруулах 0.18 сая ам. доллар болон төсөл хэрэгжүүлэх татвар болох 0.40 сая ам. долларыг тооцоогүй) санхүүжүүлсэн. НҮБХХ нь ДДБОС-гийн нэг байгууллага бөгөөд хамтран гүйцэтгэгчид нь НҮБТҮА, ОХУ-ын Байгалийн Нөөц ба Байгаль Орчны Холбооны Яам, Монгол улсын Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яам юм. Төсөл 2011 оны сүүлээс эхлэж 2015 оны 12-р сар хүртэл ойролцоо дөрвөн жилийн хугацаанд хэрэгжихээр төлөвлөгдсөн.

2. Төслийн баримт бичигт тодорхойлсоноор, төслийн зорилго нь “эдийн засгийн тогтвортой хөгжлийн хүрээнд экосистемийн тэсвэрт чанарыг хадгалах, усны чанарт заналхийлэх аюулыг бууруулах замаар Байгаль нуурын сав газрын болон Хөвсгөл нуурын байгалийн нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэхэд оршино” гэжээ. Төслийн стратеги нь Байгаль нуурын сав газарт тулгарч буй бэрхшээл, аюул заналыг бууруулахад чиглэсэн усны нөөцийн нэгдсэн менежментийн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдал юм.

3. Төслийн зорилтонд дараах гурван үр дүн гарсанаар хүрнэ гэж төлөвлөсөн:

- **Үр дүн 1: Стратеги бодлого ба төлөвлөлтийн үндэс**
- **Үр дүн 2: Усны нөөцийн нэгдсэн менежментийн бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх**
- **Үр дүн 3: Усны чанар, биологийн олон янз байдлыг хамгаалах туршлага нэвтрүүлэх.**

4. Төсөл хэрэгжих газар нутаг нь Монгол, Орос хоёр орны хил дамнан оршдог 54,000,000 га бүхий, ойролцоо Франц улсын газар нутагтай тэнцэх Байгаль нуурын сав газар юм. Төслийн стратеги нь шинжлэх ухааны мэдээллийн цуглуулга, систем ба институцийн чадавхийг хөгжүүлэх (бодлогыг хүчжүүлэх явдлыг хамруулан), болон практик газар дээр нь үзүүлэх үйл ажиллагааг цогцоор нь агуулсан юм. Арга хандлагын гол агуулга нь ДДБОС-гийн олон улсын усны салбарын арга хандлагын дагуу ХДОДШ болон СҮАХ боловсруулах явдал юм.

5. ДДБОС ба НҮБХХ-ийн үнэлгээний бодлогын дагуу дунд шатны үнэлгээг ДДБОС-гийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа бүх төслүүдэд хийх ёстой бөгөөд Байгаль нуурын төслийн хяналт үнэлгээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа юм. Үнэлгээний удирдамжид тусгагдсанаар “холбогдолтой, бүтээмжтэй, үр ашиг, үр дүн ба тогтвортой байдал” зэрэг үнэлгээний стандарт шалгууруудад тулгуурлан төслийн өнөөгийн хэрэгжилт, явцыг төслийн төлөвлөгдсөн ажил ба үр дүнтэй харьцуулан үнэлдэг. Үнэлгээг төслийн хүрэх ёстой зорилт ба үр дүнтэй өнөөгийн явц ба гэнэт гарсан үр дүнг харьцуулан хийдэг. Үнэлгээний дүнд ирээдүйд хэрэгжих адил төстэй төслүүдэд ач холбогдол бүхий сургамжуудыг олж тогтоон шаардлагатай ба зохистой зөвлөмжүүдийг өгдөг. Үнэлгээний арга зүй нь үндсэн гурван: а) төслийн ба холбогдол бүхий өөр бусад баримт бичгийг хянан, тоймлон үзэх; б) төслийн түлхүүр оролцогч ба хамтрагч талуудтай ярилцлах; с) Байгаль нуурын сав газарт хэрэгжиж байгаа төслийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж үзэх зэрэг бүрэлдэхүүнийг агуулсан хамтын оролцооны холимог арга хандлагад суурилсан. Үнэлгээг дунд шатны үнэлгээ хийх мэдээ материалыг

цуглуулж дууссаны дараа төсөл боловсруулах үе шатаас эхлэн 2014 оны 4-р сар хүртэлх хугацаанд үндэслэн хийв. 2014 оны 3-р сард төслийн баримт бичгийг тоймлон үзэж, 4-р сарын 7-18 өдрүүдэд үнэлгээ хийх ажлын томилолтоор явсан.

ҮНЭЛГЭЭНИЙ ГОЛ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ДАГУУ ГАРСАН ҮР ДҮН БА ДҮГНЭЛТ

6. Байгаль нуурын төсөл нь Орос ба Монгол улсын Засгийн Газар СҮАХ тохиролцоо ба хил дамнасан хамтын ажиллагааны механизмыг бэхжүүлэх замаар урагшлах чухал ач холбогдол бүхий шийдвэрлэх үе шатанд ирээд байна. Үүнд хил дамнасан байгалийн нөөцийн нэгдсэн менежментийг дэмжих олон улсын өнөөгийн норм ба стандартад тулгуурлан шинэчлэн дахин хянасан гэрээ болон СҮАХ ба хил дамнасан үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих институцийн хамтарсан механизмыг бэхжүүлэх зэрэг асуудал багтаж байна. Өндрөөр үнэлэгдэх олон тооны үр дүн төслийн хүрээнд гарсан боловч ирээдүйд хэрэгжүүлэх ажлыг дэмжих, Байгаль нуурын төслийн биширмээр үр дүнг тогтвортой хадгалахад хоёр улсын хамтын ажиллагааны механизмтай байх зайлшгүй шаардлагатай. Төсөл дуусахад ойролцоо 18 сар үлдсэн тул хил дамнасан хамтын ажиллагааг үргэлжлүүлэх тодорхой алхам хийх зайлшгүй шаардлагатай байна

7. Хамааралтай байдлыг харгалзан үзэхэд байгалийн нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх ба Байгаль нуурын сав газарт тогтвортой байдлыг хангахад төсөл **хамааралтай/дээд зэргийн хангалттай** гэж үзэж байна. Төсөл нь Монгол, Оросын хоорондын хил дамнасан байгаль орчны болон усны менежментийн эн тэргүүний асуудлыг дэмжин түүнчлэн хоёр орны олон тооны үндэсний бодлого ба хуулийн заалтуудтай тохирч байна. Түүнчлэн орон нутгийн нөөц ашиглагчдын хэрэгцээ, тэдний эн тэргүүний ач холбогдолтой зүйлийг нь хамаарч чадаж байна. Төсөл нь НҮБХХ-ийн улс орон тус бүрийн улс орны эн тэргүүний зүйлийг дэмжиж ДДБОС-гийн биологийн олон янз байдал болон олон улсын усны гол газар нутгийн стратегийн эн тэргүүний зүйлтэй нэг шугаманд байна. Цаашлаад төсөл нь Биологийн Олон Янз Байдлын Конвенц (CBD), Рамсарын Конвенц болон Дэлхийн Өвийн Конвенцийг оролцуулан байгаль орчны олон талт хэлэлцээрийн хэрэгжилтийг бүрэн дэмжин ажиллаж байна.

8. Төслийн үр өгөөжийг дээд зэргийн хангалттай гэж үнэлсэн. Төслийн хэрэгжилтийг хангалттайд тооцсон байхад төслийн гүйцэтгэлийг (төслийн менежмент) дээд зэргийн хангалттай гэж үнэлсэн. 2013 оны сүүл гэхэд ДДБОС-аас олгосон санхүүжилтийн гүйцэтгэл 54,9%, 2012 болон 2013 онд жилийн төсвийн гүйцэтгэлт 95%-тай, төслийн хэрэгжилт тун сайн байна. Энэ мэтээр хүрсэн амжилт нь төслийн зардалтай харьцуулахад гүн сэтгэгдэл төрүүлж байна. Төслийн менежментийн зардал төсөвлөсөн хэмжээнээс доогуур байгаа ба ДДБОС-гийн санхүүжилтээс 10% бага хэвээр үлдэнэ гэж тооцоолж байна. Төсөл хянан тогтоосон хугацаа болох 2015 оны 12-р сард дуусна гэж тооцож байна. Санхүүгийн менежментийн үйл явц олон улсын хөгжлийн төслүүдийн хэм хэмжээний хүрээнд байгаа ба НҮБХХ болон НҮБТҮА бодлого ба ёс горим болон оролцогч хоёр Засгийн Газраас тавьж буй шаардлагын дагуу хэрэгжиж байна. Төслийн хамтарсан санхүүжилт (хамтарсан санхүүжилтийн харьцаа 1 : 12.7) хэвийн байгаа ба төсөл дуусах үед анх тооцоолж байсан дүнгээс нэлээд хэмжээгээр давж мэднэ. Төсөл

хэрэгжүүлэх нэгжийн түвшин мэргэжлийн өндөр түвшинд байгаа ба онц сайн төлөвлөлт, тайлагнах, санхүүгийн менежментийг харуулж байна. Түншлэлийн төрөл бүрийн хандлагаар оролцогч талуудтай сайн тохиролцож байгаа болов ч төсөлд эзэн болох улсын хандлага Монголд Оростой харьцуулбал сул байна

9. Төслийн зорилго болон дэмжлэг үзүүлэх гурван зорилтуудад хүрэхэд Байгаль нуурын төсөл бодит дэвшил гаргах зөв зам дээр явж байна. Хугацаанаасаа саатаж (зургаан сар “эхлэлийн үе шат”) эхэлсэн хэдий ч ажлын зөвшилцсөн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны хэрэгжилт сайн байна. Төслийн үр дүн **хангалттай** гэсэн үнэлгээ авсан бөгөөд төслийн үр ашиг мөн л **хангалттай** гэж үнэлэгдсэн. Үр дүнгийн хүрээнд нь зарим нэгэн доголдол байна, учир нь төслийн үр дүнг бүрэн бүтэн, хангалттай тусгаж чадахгүй байна, түүнчлэн доод тал нь нэг шалгуур үзүүлэлтийг УЗ-ийн зөвшөөрснөөр орхиж, бусад үзүүлэлтүүдийг өөрчлөх эсвэл бууруулсан байна. Гэсэн хэдий ч төсөл нь ихэнх шалгуур үзүүлэлтүүдийг хангах зам дээр байна. Байгаль нуурын төслийн хамгийн чухал асуудал – ДДБОС-гийн олон улсын усны төслүүдийн нэгэн адил – энэ бүхний эцэст оролцогч улс орнууд тэднийг ач холбодол бүхий хамтын ажиллагааны замаар урагшлахад нь туслах СҮАХ-т тусгасан бодит, нарийвчилсан арга хэмжээг албан ёсоор зөвшөөрөх хүсэл байгаа эсэх нь эргэлзээтэй байгаа явдал юм. Байгаль нуурын төслийн өнөөгийн байдал өөдрөг харагдаж байна, учир нь хоёрхон орныг хамарч байна. Гэхдээ СҮАХ-ийн төслийг дөнгөж боловсруулж эхэлсэн ба эцсийн дүнд улс орнууд үргэлжлүүлэн албан ёсны амлалт авах хүсэл эрмэлзэлгүй байх хэд хэдэн учир шалтгаан байна.

10. Төслийн дэмжлэгээр гарсан үр дүн:

- ХДОДШ-ний төслийг 2013 оны 4-р сард боловсруулж дуусгасан;
- Хил дамнансан байгалийн нөөцийн менежментийн шинэчлэн хянасан хэлэлцээрийг Орос болон Монголын Засгийн Газарт өргөн барьж хил дамнансан хамтын ажиллагаанд ахиц гарсан;
- Сэлэнгийн бэлчрийн усны чанарын судалгаа, газар доорх усны үнэлгээ, бохирдол зөөвөрлөгдөх загварчлал ба бохирдолтой халуун цэгүүдийн үнэлгээ болон удахгүй гарах Байгаль нуурын Атлас зэргийг оролцуулан Байгаль нуурын сав газрын төрөл бүрийн асуудлаар өндөр түвшний судалгаа хийж, тайлан гарснаар Байгаль нуурын сав газрын экосистемийн динамик хөдөлгөөний талаарх ойлголт ба мэдлэг дээшилсэн;
- Усны мониторингийг уялдуулах үйл явцад мэдэгдэхүйц ахиц гаргаснаар хил дамнансан усны нөөцийн менежментийн суурь бүтэц бэхжсэн;
- Дөрвөн дэд сав газрын менежментийн төлөвлөгөө боловсруулан тэдгээрийн хэрэгжилтэнд ахиц гаргах замаар байгалийн нөөцийн нэгдсэн менежментийн чадавхи дээшилсэн;
- Биологийн олон янз байдалд ээлтэй уул уурхай болон эко-аялал жуулчлалын төлөвлөгөө ба дэд бүтцийг хамарсан ОХУ–д туршин үзүүлж байгаа үйл ажиллагааны явц сайн байна, түүнчлэн
- Байгаль нуурын Мэдээллийн Төв вэб портал байгуулснаар мэдээлэл солилцох, хуваалцах явдал эрчимжсэн.

- Байгаль нуурын өмнөд эрэгт байршдаг Эрхүүгийн цаасны үйлдвэрийн үйл ажиллагааг Оросын Засгийн Газар 2014 оны эхээр зогсоосон шийдвэр гаргасан нь дараагийн цохон тэмдэглүүштэй үйл явдал юм. Нуурыг бохирдуулж буй цорын ганц гол цэг бол энэ үйлдвэр гэж тогтоосон байсан. Хэдийгээр энэ ажил ДДБОС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийн үйл ажиллагааны дүнд гарсан шууд үр дүн бус авч Байгаль нуурын сав газрын байгаль орчны чанарын төлөв байдлыг сайжруулахаар Оросын засгийн газраас хийж буй ажил нь төслийн цар хүрээнд багтаж байгаа нь ойлгомжтой юм.

11. Байгаль нуурын төслийн хэрэгжилтийн хоёр дахь хагаст анхаарах гол асуудал нь:

- СҮАХ нь илүү бодитой, хэрэгжүүлэхүйц, ОХУ-Монгол улсын засгийн газраас дэмжлэг авч чадахуйц байх шаардлагатай;
- Хилийн ус, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах тухай Засгийн газар хоорондын гэрээг шинэчлэх, батлах болон хамтын ажиллагааны эрх зүй бүтэц, зохион байгуулалтын үндэс суурийг сайжруулах ажилд ахиц гаргах хэрэгтэй байна;
- Сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд анхаарч, дэмжих;
- Монгол улсын сав газрын захиргаад болон зөвлөлийн боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх тал дээр дэмжлэг үзүүлэх;

12. Тогтвортой байдлын үнэлгээг төслийн дунд шатанд хийхэд хүндрэлтэй боловч төслийн үр дүнтэй холбоотой эрсдэл харьцангуй бага гэж үзээд тогтвортой байдлыг дунд зэрэг гэж үнэлэв. Одоогоор санхүү, бүтэц зохион байгуулалт, удирдлагын эрсдэл бага. Харин нийгэм, улс төрийн тогтвортой байдлын эрсдэлийн хувьд төсөл хэрэгжиж дуусах үед Монгол, ОХУ-аас СҮАХ-ийг хүлээн зөвшөөрч, хил дамнасан сав газрын байгалийн нөөцийн нэгдсэн менежментийн чиглэлд хамтарч ажиллахад бэлэн байх эсэх, хилийн усны Засгийн газар хоорондын гэрээг шинэчлэн батлах ажилд хир зэрэг ахиц гарах зэргээс хамаарсан эрсдэл байх үндэслэлтэй. Байгаль орчны хувьд Монголын талд байгуулах усан цахилгаан станцтай холбоотой эрсдэл байж болох юм.

ЗӨВЛӨМЖҮҮД

1. **Зөвлөмж 1:** СҮАХ-ийг боловсруулахдаа Монгол улсын аймаг, сум, орон нутгийн засаг захиргааны байгууллагыг татан оролцуулах, түүнчлэн СҮАХ-ийн хэрэгжилтийг хангах үүднээс Сэлэнгэ мөрний сав газарт багтдаг аймаг, сумын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах хэрэгтэй. Түүнчлэн төслөөс СҮАХ боловсруулалтын эхний шатанд хамтрагч талуудтай зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах (2014 оны 3 улиралд) ажлыг дэмжих шаардлагатай. Энэхүү ажлыг зохион байгуулахад шаардлагатай эх үүсвэрийг Үр дүн 3-аас Үр дүн 1 рүү шилжүүлэх замаар гаргаж болох юм. Уг ажлыг тухайн аймгуудын Байгаль орчны газартай хамтран зохион байгуулах нь зөвлөж байна [БХЗГ, БОНХЯ, Монгол].

2. **Зөвлөмж 2:** Төслөөс Монгол улсын Засгийн газарт Хилийн ус, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах тухай гэрээний төслийг судлах, дүн шинжилгээ хийх, Оросын талтай хамтарч ажиллахад нь бүхий л талын дэмжлэг

туслалцааг үзүүлэх хэрэгтэй. Үүнд өмнө нь хэрэгжиж байсан тэтгэлэгт, ижил төстэй бусад төслийн үйл ажиллагаа, хууль эрхзүйн орчинд дүн шинжилгээ хийх, Хуульзүйн яамтай хамтарч ажиллах, зөвлөлгөө авах зэрэг хэлбэрүүд байж болно. Хил дамнасан сав газрын асуудал гэдэг утгаараа Байгаль орчин ногоон хөгжлийн яамнаас гадна Гадаад хэргийн яамыг татан оролцуулах, түүнчлэн Монголын НҮБХХ хамтрах боломжтой юм.

3. **Зөвлөмж 3:** Төслийн төгсгөлийн шатны стратегийг 2014 оны сүүлээр боловсруулж, 2015 оны эхээр гол оролцогч, хамтрагч талуудаар хэлэлцүүлэх шаардлагатай. Төгсгөлийн шатны стратегит төслөөс гарсан үр дүнг тогтвортой хадгалах, үргэлжлүүлэх, хариуцах эзэн, үүрэг ролийг нь тодотгон тусгаж өгөх хэрэгтэй. Тухайлбал, Байгаль нуурын мэдээллийн төвийн ажлыг хэрхэн цааш үргэлжлүүлэх, зохион байгуулах зэргийг тодорхой тусгавал зохино [ТХН, ТУЗ].

4. **Зөвлөмж 4:** Төслөөс Монгол улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн хүрээнд хэрэгжих загвар дэд төслүүдийг таниулах, хэрэгжүүлэх бүхий л нэмэлт нөөц, боломжийг судлан дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. Уг төслийн хүрээнд газар дээрээ хэрэгжих практик үйл ажиллагааг Монгол улсын хэмжээнд харьцангуй бага хийсэн ба иймэрхүү төрлийн ажил нь хамтрагч талуудыг тохиролцоонд хүрэх арга замд сургах, мэдлэгийг нэмэгдүүлэх давуу талтай учраас Монгол улсын аймаг, сум, орон нутгийн засаг захиргааны төлөөллийг дэмжиж оролцуулвал илүү үр өгөөжтэй байх болно [ТУЗ].

5. **Зөвлөмж 5:** Байгаль нуурын төслөөс ДДБОС/Жижиг төслийн хөтөлбөртэй Монголд хамтран ажиллах боломжийг судалж, Байгаль нуурын мэдээллийн төвийн үйл ажиллагааг дэмжин идэвхижүүлэх, Монгол улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн хүрээнд биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлийн ажлыг хийх, тусган оруулах хэрэгтэй [ТХН, НҮБХХ Монгол, ДДБОС/ЖТХ, Монгол]

6. **Зөвлөмж 6:** Төсөл Хилийн ус, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах тухай Засгийн газар хоорондын гэрээг шинэчлэн батлах ажилд хоёр орныг татан оролцуулах, дэмжих олон төрлийн арга хэмжээ, алхамуудыг хийх шаардлагатай байна. Үүнд Монгол, Орос улсын хооронд усны хамтын ажиллагаа үүсч хөгжсөний 20 жил (хэрвээ 1974 оноос эхэлсэн гэж үзвэл 40 жил) ойг тохиолдуулсан ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслэл ашиглан арга хэмжээ зохион байгуулж боломжтой. Энэхүү арга хэмжээг хилийн усны менежментийн өнөөгийн байдалтай холбоотой гол асуудлыг хөндсөн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэргээр өргөтгөж болох юм [ББНЯ, БОНХЯ, ТХН, ТУЗ].

7. **Зөвлөмж 7:** Шинэ хамтарсан комисс байгуулахын өмнө өнөөгийн Хилийн усны хамтарсан комиссын бүтэц зохион байгуулалтыг сайжруулах ажлыг дэмжих, төслөөс СҮАХ-ийн хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагааг комисст танилцуулах, төлөвлөлтөнд нь тусгах, нэгтгэх тал дээр ОХУ, Монгол улсын Засгийн газар болон бусад хамтрагч талуудтай нягт ажиллах шаардлагатай. Ингэснээр төслөөс гарах үр дүнгийн тогтвортой байдал нэмэгдэж СҮАХ хэрэгжих эхний алхам тавигдах юм [ББНЯ, БОНХЯ].

8. **Зөвлөмж 8:** Байгаль нуурын мэдээллийн төвийн вэб хуудас нь бусад интернэтийн эх үүсвэртэй тухайлбал Монгол улсын БОНХЯ, ОХУ-ын БНЯ, Буриад улсын Байгаль орчны агентлагууд, Монгол улсын аймгийн веб хуудсанд холбох байх хэрэгтэй ба Байгаль нуурын мэдээллийн төвийн вэб хуудас нь олон нийтийн

мэдээллийн чухал эх үүсвэр болох учраас бусад вебд суурилсан мэдээллийн эх үүсвэрүүдтэй аль болох өргөн хүрээгээр холбох шаардлагатай байна. Үүний тулд хайлтын сайн системтэй, төслийн болон бусад хэвлэлийн эх үүсвэрүүд рүү холбогддог болох шаардлагатай юм [ТХН, БНМТ].

9. **Зөвлөмж 9:** Төслөөс Монгол улсад хэрэгжиж буй усны сав газрын менежментийн хүрээнд байгуулагдсан сав газрын захиргаад ба зөвлөлүүдийн боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх тал дээр боломж гаргаж, хамтарч ажиллах шаардлагатай. Тухайлбал сав газрын зөвлөлийн чадавхийг сайжруулснаар олон нийт ба сав газрын менежментийн БОНБҮ-ний мэргэжлийн хүмүүсийн хоорондын ойлголцол мэдлэгийг дамжуулах холбоос болох юм. Түүнчлэн ГСГЗахиргаа нь Монгол оронд УННМ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол байгууллага учраас боловсон хүчнийг нь УННМ-ийн чиглэлээр сургах, техникийн хувьд бэхжүүлэх шаардлагатай юм. Эг, Идэр голын Сав газрын захиргаад дөнгөж байгуулагдаад байгаа бөгөөд Байгаль нуурын төслийн хүрээнд эдгээр сав газруудын УННМ төлөвлөгөөг боловсруулсан нь төслийн хувьд төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд нь дэмжих сайхан боломж гарч байгаа юм [ТХН, ТУЗ, БОНХЯ].

10. **Зөвлөмж 10:** Төслийн хүрээнд хариуцлагатай уул уурхайн чиглэлээр Монголд үйл ажиллагаагаа өргөтгөх шаардлагатай байна. Уг төслийн явцад Оросын талд хэрэгжүүлж байгаа биологийн олон янз байдалд ээлтэй уул уурхайн дэд төслүүдээс гарсан үр дүнг тэмдэглэн, Монголын мэргэжил нэгтэй хүмүүст сургах, таниулах шаардлагатай. Түүнчлэн Монгол улс дах оролцогч ба хамтрагч талуудтай нэгдэн уул уурхайн үйлдвэрлэлд нэвтэрч байгаа тэргүүн туршлагыг олж тогтоон, түүнийг түгээх, нэвтрүүлэх ажлыг хийх хэрэгтэй. Азийн сангаас уул уурхайн чиглэлээр хамтрагч талуудын дунд хурал зохион байгуулж байсан бөгөөд уул уурхай нь Байгаль нуурын сав газрын Монголын талд анхаарал татсан чухал асуудлын нэг билээ. Эдгээр ажлыг хийж гүйцэтгэхэд төсөв хөрөнгө харьцангуй бага шаардагдана. Үүнээс гадна төсөл Монголд хариуцлагатай уул уурхайн чиглэлээр дэд төслүүдийг (тэр тусмаа гар аргаар олборлолт хийдэг) хэрэгжүүлэх боломжийг судлах ёстой ба үүнийг заавал биологийн олон янз байдлын төсвөөс авах бус Олон улсын усны асуудлын сан эсвэл ДДБОС/Жижиг төслийн хөтөлбөр зэрэг бусад эх үүсвэрээс хайх боломжтой [ТХН, ТУЗ].

11. **Зөвлөмж 11:** УННМ-ийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор иргэдийн оролцоотой усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөр хийх боломж, нөхцлийн талаарх үнэлгээг төслөөс хийх хэрэгтэй. Энэ төрлийн хяналт шинжилгээний хөтөлбөр нь усны чанарын явцад байнгын хяналт тавих боломжийг олгох ба Монгол орны гол мөрөн нь өөрөө цэвэрших өндөр чадвартай учраас бохирдолын талаар мэдээлэл ирснээс хойш очих, дээж авах хугацаанд бохирдлын хэмжээ өөрчлөгдөх, шингэрэх магадлалтай. Иргэдийн оролцоотой усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөр нь олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, байгаль орчны талаарх сургалтыг дэмжих давхар зорилтыг агуулах бөгөөд үнэ өртөг багатай мэдээлэл цуглуулах боломжийг олгодог давуу талтай. Ийм төрлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн жишээнд Жоржийн (АНУ) гол мөрнийг хамгаалах хөтөлбөр (<http://www.georgiaadoptastream.com/db/>), мөн Коок Инлеткиипэрийн (Аляска, АНУ) иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (<http://inletkeeper.org/clean-water/citizen-monitoring>) орно [ТХН, ТУЗ].

12. **Зөвлөмж 12:** Байгаль нуурын төслийн техникийн гол экспертүүд 2014 онд ажлаа эхлэх НҮБХХААБ/ДДБОС төслийн нээлтийн ажилд оролцон хоёр төслийн хооронд уялдуулах ажлыг хийх хэрэгтэй. Хамтын ажиллагааны нэг гол чиглэл нь Экосистемийн үйлчилгээний төлбөр бөгөөд НҮБХХААБ-ын төсөл Монголд загвар газрыг сонгохоор төлөвлөж байна [ТХН, НҮБХХ, НҮБХХААБ].

13. **Зөвлөмж 13:** ХДОДШ-ний 1-2 дугаар хуудсанд нэгтгэсэн Байгаль нуурын сав газарт тулгараад байгаа гол асуудалд анхаарал хандуулах, мэдээлэх, сурталчлах ажлыг Монголын талд дэмжиж хийх хэрэгтэй байна. Хамтрагч талуудын зүгээс эдгээр асуудлыг шийдвэр гаргах түвшний хүмүүст ойлгуулах, мэдээллийг нь нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх нь чухал байгааг тэмдэглэсэн болно [ТХН].

14. **Зөвлөмж 14:** Экосистемийн үйлчилгээний төлбөрийн үнэлгээний ажлыг хил дамнасан сав газрын хэмжээнд хийх боломж байна. Экосистемийн үйлчилгээний төлбөрийг сав газрын хэмжээнд хийсэн жишээ олон байгаа боловч хил дамнасан сав газарт хийсэн ажил бараг байхгүй юм. Байгаль нуурын сав газарт төлбөрийн схем боловсруулах боломж байгаа, учир нь сав газрын доод хэсэгт орших ОХУ нь Монголыг бодвол илүү нөөц баялагтай (ДНБ ба хөгжлийн хувьд харьцангуй өндөр түвшинтэй). Экосистемийн үйлчилгээний төлбөрийн схемийг бэлэн бус төлбөрийн хэлбэрээр хийж болох бөгөөд тухайлбал Монгол улс Сэлэнгэ мөрний усны чанарын тодорхой үзүүлэлт эсвэл тусгай бүсийн ойн талбайг тодорхой хэмжээнд барихаар баталгаа гаргасан тохиолдолд ОХУ техникийн тусламж болон мод экспортлох эсвэл хилийн ойролцоох сумын хөгжлийг дэмжих зэргээр тохиролцож болох юм. Ийм схемийг одоо хэрэгжиж байгаа УННМ-ийн төсөл дуусахаас өмнө хийх боломжгүй ч туршилт, судалгааны ажлыг эхлэх, концепцийг нь боловсруулах, тодорхой саналыг СҮАХ-т тусгах хэрэгтэй. Ийм схем боловсруулах нь дэлхий нийтийн ач холбогдолтой ч байж болох юм [ТХН, ТУЗ, СҮАХ-ийн баг].

15. **Зөвлөмж 15:** Дунд шатны үнэлгээнээс төсөлд бусад дагалдах эх үүсвэрээс оруулж буй хөрөнгөнд санхүүгийн бүртгэл мэдээлэл хийх шаардлагатайг зөвлөж байна. ОХУ-ын Байгалийн бүс нутагт хөрөнгө оруулалт хийх хөтөлбөрийн хүрээнд анх төлөвлөсөн хэмжээнээс илүү санхүүжилт хийгдсэн гэж үзэж байна. Нөгөө талаар хөрөнгө оруулалтын хэмжээнээс гадна хөрөнгө оруулагчдын тоо, түүний хэлбэр нь хамтрагч талуудын эзэмшил, дэмжлэгийг харуулах индикатор үзүүлэлт болох юм. Тиймээс төсөлд хамтран санхүүжилт хийсэн бүх оролцогч талуудыг бүртгэж байх нь ихээхэн чухал юм [ТХН].

16. **Зөвлөмж 16:** Төсөлд хийсэн дунд шатны үнэлгээний дүнд үндэслэн төслөөс хүрэх ерөнхий үр дүнг төслийн хэрэгжилтийн хоёр дах үе шатанд өөрчлөх шаардлагагүйг зөвлөж байна. Ялангуяа төслийн үр дүнгийн хэсэг 2-ийн үзүүлэлтүүд төсөлд төлөвлөсөн байсан үр дүнг илэрхийлж чадахгүй байна [ТУЗ].

БАЙГАЛЬ НУУРЫН ТӨСЛИЙН ДУНД ШАТНЫ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ХҮСНЭГТ

Үнэлгээнүүд:			
1. Хяналт шинжилгээ ба үнэлгээ	үнэлгээ	2. Хэрэгжилт & Биелэлт	үнэлгээ
Хяналт шинжилгээ & Үнэлгээ эхний шатны дизайн/төлөвлөгөө	Бүрэн хангалттай	НҮБХХ-ийн гүйцэтгэлийн чанар	Хангалттай
Хяналт шинжилгээ & Үнэлгээ Төлөвлөгөөний хэрэгжилт	Хангалттай	Хэрэгжүүлэгч агентлагуудын гүйцэтгэлийн чанар	Дээд зэргийн хангалттай
Ерөнхий чанар Хяналт&Үнэлгээ	Хангалттай	Гүйцэтгэлийн ерөнхий чанар	Хангалттай
3. Үр дүнгийн үнэлгээ	үнэлгээ	4. Тогтвортой байдал	үнэлгээ
Хамаарал/харилцаа	Дээд зэргийн хангалттай	Санхүүгийн эх үүсвэр	Бүрэн боломжийн
Үр ашигтай байдал	Хангалттай	Нийгэм, улс төрийн	Боломжийн
Бүтээмж	Дээд зэргийн хангалттай	Засаглал ба бүтэц зохион байгуулалт	Боломжийн
Төслийн үр дүнгийн ерөнхий үнэлгээ	Хангалттай	Байгаль орчин	Бүрэн боломжийн
5. Нөлөөлөл	үнэлгээ	Тогтвортой байдлын ерөнхий үнэлгээ	Бүрэн боломжийн
Байгаль орчны төлөв байдлын эерэг өөрчлөлт	Ерөнхийдөө хангалттай		
Байгаль орчны доройтлын бууралт	Ерөнхийдөө хангалттай		
Байгаль орчны төлөв байдлын/доройтлын өөрчлөлтийн явц	Ерөнхийдөө хангалттай	Нийт үнэлгээ	Хангалттай